

Хоёр. Бизнесийн байгууллагын менежментийн чадамжийн судалгааны загвар

1-Р ХЭСЭГ: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын төрөл /Тохирох нэрийн өмнөх дугаарыг дугуйлна /. Үүнд:

1. ХХК 2. ХК 3. Хоршоо 4. Нөхөрлөл 5. Бусад

Үйл ажиллагааы чиглэл: _____

Ажиллагчдын тоо: _____

Санал асуулгад оролцогчийн албан тушаал /Тохирох нэрийн өмнөх дугаарыг дугуйлна/. Үүнд:

1. Байгууллагын дарга /захирал, дэд захирал/ 2. Нэгж хэсэг- албаны дарга, ахлагч 3. Ерөнхий болон чиг үүргийн менежер 4. Ажилчин, албан хаагч 5. Хөрнөгө оруулагч, хувьцаа эзэмшигч 6. Хамтрагч 7. Нийлүүлэгч, захиалагч 8. Эцсийн хэрэглэгч 9. Бусад

2-Р ХЭСЭГ: МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлбар 1

Хүснэгтэд өгөгдсөн 10 бүлэг үзүүлэлтээс эхний ээлжинд менежментийн чадамжийн үйл явцын 9 бүлэг үзүүлэлтээр үнэлгээ хийнэ. Тэгэхдээ уг үйл явц ямар түвшинд хэрэгжиж байгаагаас хамааруулан дор дурдсан үнэлгээний аль нэгийг сонгон дугуйлна. Үүнд:

- | | |
|---|---|
| ✓ Үгүй, буюу уг үйл явц одоогоор хэрэгжиж эхлээгүй бол | 1 |
| ✓ Тийм, дөнгөж эхлэх төдий байгаа бол | 2 |
| ✓ Тийм, байгууллагын зарим хэсэгт хааяа хэрэгждэг бол | 3 |
| ✓ Тийм, байгууллагын дийлэнхэд нь хэрэгжиж байгаа бол | 4 |
| ✓ Тийм, байгууллагын хэмжээнд бүхэлдээ хэрэгжиж байгаа, цаашид сайжруулах бол | 5 |
| ✓ Тийм, байгууллагын хэмжээнд ажил хэрэг болж бүрэн хэвшсэн бол | 6 |

эдгээр болно.

I. АЛСЫН ХАРААТАЙ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА

- | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1. Байгууллагыг хөгжүүлэх алсын хараа, зорилго, зорилтууд тодорхой бөгөөд түүнийг хэрэгжүүлэхийн төлөө удирдлагын бүх түвшинд хамтран ажилладаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 2. Байгууллагын алсын харааг нийт ажиллагчид өөримсгөөр хүлээн авч түүнд итгэл үнэмшилтэй ханддаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 3. Байгууллагын алсын хараа, түүийг хэрэгжүүлэхийн тулд дэвшүүлсэн зорилтууд нь удирдлагын шийдвэр гаргах үйл явцийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болдог | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

II. ГҮЙЦЭТГЭЛИЙН МАНЛАЙЛАЛ

- | | | | | | | |
|--|---|---|---|---|---|---|
| 1. Удирдлагын зүгээс байгууллага хамт олныхоо өмнө тавигдсан зорилго, зорилтын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж өөрийн биеэр үлгэрлэн манлайлдаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 2. Байгууллагын удирдлага нөхцөл байдлыг бодитой үнэлж, эрсдлийг тооцон, шаардлагатай өөрчлөлт шинэчлэлийг цаг тухайд нь хийж хэрэгжүүлдэг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 3. Байгууллагын ажлын үр дүнг түүний өрсөлдөгч болон ижил төстэй байгууллагатай харьцуулахад байнга сайжирч илүү өндөр түвшинд хүрч байгаа | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 4. Байгууллагын алба, хэлтэс, нэгж хэсгүүд төлөвлөгөө, гэрээ, контрактаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн төлөө бие даан, санаачлагатай ажилладаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

III. ХҮМҮҮСИЙГ УДИРДАХ

- | | | | | | | |
|--|---|---|---|---|---|---|
| 1. Хүмүүсийг ажилд авах, сонгон шалгаруулах зөв, оновчтой, шудрага тогтолцоог бүрдүүлж, түүнийгээ удирдлагын бүх төвшинд мөрдөж ажилладаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 2. Хүний нөөцийн төлөвлөлтийг жил бүрийн бүрийн бизнес төлөвлөгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгон хийж хэрэгжүүлдэг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 3. Удирдлагын зүгээс хүмүүст тогтвор суурьшилтай, илүү үр бүтээлтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж тэдний ажил мэргэжил дээрээ өсөх, албан тушаал ахиж дэвших сонирхлыг дэмждэг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

IV. САНХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТ

- | | | | | | | |
|--|---|---|---|---|---|---|
| 1. Байгууллагын удирдлага нь бизнесийн өсөлтийг хангах, үр ашгийг дээшлүүлэх зүрилгод чиглэсэн байнгын системтэй бодлого, үйл ажиллагаа явуулдаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 2. Удирдлагын зүгээс санхүүгийн төлөвлөлт, нягтлан бодох бүртгэл, мөнгө хөрөнгийн урсгал, хөрөнгө оруулалт, тайлан тооцооны үнэн зөв байдал, үр ашигтай гүйцэтгэлд хяналт тавьж тодорхой чиглэл удирдлагаар хангаж ажилладаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 3. Банк, санхүү, татвар, аудитын байгууллагуудтай үр дүнтэй холбоо харилцаа тогтоон, хамтран ажилладаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

V. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- | | | | | | | |
|--|---|---|---|---|---|---|
| 1. Байгууллагын удирдлагаас нэгж хэсэг, ажилтан нэг бүрийн эрх үүрэг, хариуцах ажлын чиглэл, хүрээг нарийн тодорхойлсон дүрэм журам боловсруулж түүнийгээ мөрдлөг болгодог | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 2. Байгууллагын өнөөгийн бүтэц, зохион байгуулалт нь шат дамжлагыг багасгах, нэгж хэсгүүдийн ажлын уялдаа холбоо, хамтач ажиллагааг сайжруулах зорилтод нийцдэг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 3. Удирдлагын зүгээс хувь хүний бүтээлч бие даасан байдлыг багаар ажиллах арга маягтай зөв оновчтой хослуулахад анхаарч ажилладаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

VI. МЭДЛЭГИЙН МЕНЕЖМЕНТ

- | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1. Байгууллага, хувь хүмүүсийн аль алинийг нь тасралтгүй суралцагч байлгахын төлөө удирдлагын зүгээс байнга санаа тавьж тодорхой ажил зохиодог | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 2. Удирдлага нь мэдээллийн технологийн ололтыг эзэмшин, түүнийг байгууллагынхаа үйл ажиллагаанд зохистой хэрэглэх арга хэлбэрийн олж ажилладаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 3. Удирдлагын зүгээс ажиллагчдын дунд мэдлэг, туршлагаа хуваалцах, харилцан тусалж хамтран ажиллах, нөхөрсөгөөр өрсөлдөх, шилдэг ололтыг дэлгэрүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч дэмждэг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

VII . ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

- | | | | | | | |
|--|---|---|---|---|---|---|
| 1. Байгууллагын удирдлага үр ашигтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх тодорхой бодлого үйл ажиллагаа явуулдаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|--|---|---|---|---|---|---|

- | | | | | | | |
|--|---|---|---|---|---|---|
| 2. Байгууллагын удирдлага хэрэглэгч, нийлүүлэгч, хөрөнгө оруулагч талуудтай харилцан ашигтай хамтын ажиллагаа тогтоож өөрийн байгууллагын талаар эерэг дүр төрхийг бий болгох талаар санаачлагатай ажилладаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|--|---|---|---|---|---|---|

VIII. ИННОВАЦИ /ТӨГӨЛДӨРШИЛ/

- | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1. Төгөлдөршил нь бизнест шинэ үнэ цэнийг бие болгох, ажлын гүйцэтгэлийг илүү өндөр түвшинд гаргах гол арга хэрэгсэл гэдгийг удирдлагын бүх түвшинд хүлээн зөвшөөрч хамтран ажилладаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 2. Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг тасралтгүй төгөлдөршүүлэх тусгай төсөл, хамт олны дунд шинийг санаачлах, бүтээлч уур амьсгалыг бүрдүүлэх асуудлыг тэргүүн зэрэгт анхаардаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 3. Бүтээмжийг дээшлүүлэх, хаягдлыг багасгах, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарыг сайжруулах сорилт туршилт, судалгааны ажлыг дэмжиж үр дүнг нь үйлдвэрлэлд нэвтрүүлдэг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

IX. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- | | | | | | | |
|--|---|---|---|---|---|---|
| 1. Дотоодын хяналт шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулж үйл ажиллагаандаа хөндлөнгийн санал зөвлөмжийг тусган, нээлттэй ил тод байдлыг эрхэмлэн ажилладаг | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 2. Хууль дээдлэх, байгаль орчинд ээлтэй байх, хэрэглэгчдийн эрх ашгийг эрхэмлэх зэрэг нийгмийн хариуцлагын зарчмыг үйл ажиллагааныхаа мөрдлөг болгодог | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

3. Хувьцаа эзэмшигч, өмчийн эзэд, гүйцэтгэх удирлагын зүгээс байгууллагын хөгжлийн аливаа асуудлыг шийдвэрлэхдээ ажиллагчид болон хамтрагч бусад талуудын ашиг сонирхлыг харгалзан үздэг
- | | | | | | | |
|--|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|--|---|---|---|---|---|---|

Тайлбар 2

Үйл ажиллагааны үр дүнгийн Х дахь бүлэг үзүүлэлтүүд нь байгууллагын менежментийн чадамжийн голлох үзүүлэлт бөгөөд тэдгээрийг үнэлэхдээ үзүүлэлт тус бүр дээр :

- | | |
|--|---|
| ✓ Үр дүн байхгүй буюу хангалтгүй | 1 |
| ✓ Байдал сайжрах анхны шинж тэмдгүүд илэрсэн | 2 |
| ✓ Байдал сайжирч зарим чиглэлд гүйцэтгэл сайжрах хандлага бий болсон | 3 |
| ✓ Олон чиглэлд гүйцэтгэл сайжирч байгаа | 4 |
| ✓ Ихэнх чиглэлд гүйцэтгэл сайжирсан | 5 |
| ✓ Дээд зэргийн гүйцэтгэлтэй, салбартаа тэргүүлэгч болж чадсан гэсэн шатлалыг баримтлан аль тохирох дугаарыг сонгож дугуйлна. Үүнд: | 6 |

Х. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДИТ ҮР ДҮН

- | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1. Гүйцэтгэлийн ерөнхий үр дүн нь өрсөлдөгчийнхөө хэмжээнд хүрсэн буюу давж гарсан | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 2. Бизнесийн хэмжээ, цэвэр ашиг, шинээр бие болсон нэмүү үнэ цэнэ нь сүүлийн жилүүдэд тогтвортой хадаглагдсан буюу нэмэгдэж сайжирсан | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

Тайлбар 3

Байгууллагын менежментийн чадамжийн үйл явцын болон үр дүнгийн үзүүлэлтэд дээрх байдлаар үнэлгээ дүгнэлт өгсний дараа тэдгээрийг нэгтгэж дүн шинжилгээ хийх чухал ажил үлдэнэ. Энэ ажилд шаардлагатай мэргэжлийн дэмжлэг тусалцааг холбогдох байгууллагаас үзүүлж болно. Үүгээр тухайн байгууллагын менежментийн чадамжид үнэлгээ өгөх ажил дуусдаг. Харин энэ удаад тус холбоо байгууллагын менежментийн чадамжид нэн чухал нөлөө бүхий бизнесийн бодлого эрх зүйн орчин, сургалт зөвлөх үйлчилгээний талаар судалгаанд оролцогчдын дунд давхар санал асуулт хийсэн гэдгийг дурдах хэрэгтэй. Дэлгэрэнгүйг дараахь хэсгээс үзнэ үү.

4-Р ХЭСЭГ: БИЗНЕС ЭРХЛЭХ БОДЛОГО ЭРХ ЗҮЙН ОРЧИН, СУРГАЛТ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Бизнес эрхлэх бодлого эрх зүйн орчны талаарх Таны үнэлгээ. Үүнд:

Маш сайн - 5 Сайн - 4 Дунд - 3 Хангатгүй - 2 Маш хангалтгүй - 1

Энэ талаар цаашид юуг голлон анхаарвал зохих вэ? Саналаа бичнэ үү.

.....
.....

Бизнесийн байгууллагуудын ажилд яам, агентлаг, засгийн газрын бусад байгууллагаас үзүүлэх дэмжлэг, оролцоо, зохицуулалтын талаарх Таны үнэлгээ

Маш сайн - 5 Сайн - 4 Дунд - 3 Хангатгүй - 2 Маш хангалтгүй - 1

Энэ талаар цаашид юуг голлон анхаарвал зохих вэ? Саналаа бичнэ үү.

.....
.....

Манай орны их дээд сургууль төгсөгчдөөс сүүлийн жилүүдэд бизнесийн байгууллагад ажилд орогчдын мэргэжил мэдлэг, ур чадвар ямар түвшинд байна гэж Та үздэг вэ?

Маш сайн - 5 Сайн - 4 Дунд - 3 Хангалтгүй - 2 Маш хангалтгүй - 1

Энэ талаар цаашид юуг голлон анхаарвал зохих вэ? Саналаа бичнэ үү.

.....
.....